



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 0234


Улаанбаатар хот

Барилга байгууламж данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/21 дүгээр тогтоол, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн 49 886 515 /дөчин есөн сая найман зуун наян зургаан мянга таван зуун арван таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хуучин барилга байгууламжийг нээлттэй дуудлагын худалдагаар хувьчилсан тул данс бүртгэлээсээ хасахыг Ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэгт зөвшөөрсүгэй.
2. Өмчийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийхийг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга А.Мөнгөнд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050000723